

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 4 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Засаг даргын тамгын газар нь байгууллагын дотоод хурлыг 7 хоног бүрийн пүрэв гаригт тогтмол хийж цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцож, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллаж байна. Энэ сард Засаг дарга, Засаг даргын орлогчоор ахлуулсан 2 ажлын хэсэг гарч 5 багийн малчдаар баг тойрох ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сан, бэлчээр ашиглалтын журмыг танилцуулж. Малчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулж татварын орлого, нийгмийн даатгалын төлөлт, эрүүл мэндийн даатгалын хамрагдалт, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдаж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээлэл өгч малчдын санал бодлыг сонсож ажиллаа. Газрын тухай хуулийн төсөлд бэлчээр ашиглалтын талаар нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцүүлгийг УИХ-ын гишүүн Ц.Идэрбатаар ахлуулсан ажлын хэсэг тус суманд 4 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт 4 сумын холбогдох албан хаагчид болон манай сумаас малчдыг төлөөлөл болж 100 малчин оролцож санал бодлоо солилцлоо. 5-р багийн нутаг бутангийн айраг гэх газарт малчин Н.Цэгмидийн хотонд хонины цэцэг өвчний шинж илэрч сумын засаг даргын 03 дугаар сарын 28 ны өдрийн А/39 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоож аймгийн онцгой байдлын газрын орлогч дарга н.Гантаар ахлуулсан ажлын хэсэгтэй сумын онцгой комисс хамтран ажиллаж шуурхай арга хэмжээ авч ажилласан. Үүнд хөдөлгөөнт пост-4, суурин пост-1, устгалын ажлын хэсэг-1, тарилгын ажлын хэсэг-4, нийт 26 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж өвчилсөн 86 тооны хоныг зориулалтын устгалын цэгт устгаж халдваргүүжүүлсэн. Сумын засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 20 өдрийн А/52 тоот захирамжаар хорио цээрийн дэглэмийг бууруулж ажиглалтад байна. Дээрх ажилд 1975740 төгрөгийг орон нутгийн хөгжлийн сан, малын татварын орлогоос зарцуулсан байна. 4 дүгээр сарын 12-ны өдөр Нийгмийн даатгалын хэлтсийн дарга П.Амараар ахлуулсан аймгийн ХАБЭА-н зөвлөлийн ажлын хэсэг тус суманд ажиллаж ХАБЭА-н сарын аяны ажлын явц, албан байгууллага, аж ахуй нэгжийн ХАБ-ын орчин бүрдүүлэлттэй танилцаж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл хуралдаж 2023 онд хийх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэж баталсан. Гэнэтийн аюулаас болж ихээхэн хохирол амссан зорилтот өрхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор Улсын тэргүүний цэцэрлэгээс зохион байгуулсан ХАЙРЦАГ-ДҮҮРЭН-ХАЙР хандивын аянд тамгын газрын албан хаагчид нэгдэж, мөнгөн бол эд материалын дэмжлэг үзүүлсэн. Сумын төсөвт 5-н байгууллага, 1 ОНӨААТҮГазар нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт тайлагнаж байгууллага бүр “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч, сумын төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгдсэн тайландаа “Өөрчлөлтгүй” дүгнэлт аваад байна.

04.12-нд сумын төсвийг олон нийтэд ил тод, энгийн, ойлгомжтой харуулах зорилгоор “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс боловсруулсан аргачлалын дагуу сумын 2023

оны төсвийн мэдээллийг уг загварт оруулан бэлтгэж зурагт хуудас болгон ОНХС-ын нэгдсэн бүлэг болон сумын вэб сайт, цахим группт тус тус байршуулсан.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

ЭМТөвд төрсөн эх – 0

Нийт төрсөн эх – 18

Нас баралт – 8 / хавдар-3, бусад-5/

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч – 178

Ор хоног – 1216

Нийт үзлэг – 1338

Эрэгтэй – 570

Эмэгтэй – 768

Урьдчилан сэргийлэх үзлэг –269

Идэвхитэй хяналт – 442

Жирэмсний хяналт-21/18/86%

Амбулаторийн	үзлэг	–		471
Анхан	–			213
Давтан	–			258
Гэрийн	дуудлага	–		142
Халдварт	өвчлөл	–	–	0
Шинэ-0				
Хуучин				-0
Түргэн	тусламжийн	дуудлага	–	261
Алсын	дуудлага	–		109
Осол	гэмтлийн	дуудлага	–	9
Эрт	илрүүлэг			үзлэг
Хөхний	өмөн	–	870/256/29,4%	
Умайн	хүзүүний	өмөн	–	220/38/17,2%
Артерийн	даралт	ихдэлт	–	940/197/20.9%
Чихрийн	шижин			– 1400/321/23%

Сургалт сурталчилгаа

Тараах материал-6

Цахим хуудас-52 төрлийн мэдээлэл байршуулж 10512 хүний хандалт

Танхимын сургалт -4 удаа 112 хүн хамруулсан

Архив албан бичиг хөтлөлтийн сургалт “Хөтлөх нэрийн жагсаалт” хэрхэн хөтлөх тухай сургалтанд албан байгууллагуудын бичиг хэрэг хариуцсан ажилтанууд хамрагдсан.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан болон ХАБЭА тухай сургалтанд багийн эмчийг хамруулсан.

Магадлан шинжээчийн баг ЭМТ – ийн 2019 – 2023 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 04 сарын 13, 14 нд өдрүүдэд ажилласан.

Боловсролын чиглэлээр:

2023 оны 04-01-ээс 02 хооронд Баруун-урт суманд биеийн тамирын тэргүүний ажилтан, боловсролын тэргүүний ажилтан, спортын дэд мастер С.Энхтөрийн нэрэмжит өсвөрийн жүдо бөхийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн Баруун-Урт хотноо амжилттай зохион байгуулагдлаа. энэхүү тэмцээнд: алт 1, мөнгө 3, хүрэл 3 тус тус медаль хүртэж амжилттай оролцлоо.

Мэргэжлийн бүлгийн төлөвлөлтийн хүрээнд 1-р сургуулийн англи хэлний багш Монгол улсын зөвлөх багш Бадрахцэцэг Мижээ БШУГ-ын зөвлөх багш Martha M Taylor, 1-р сургуулийн Нийгмийн ажилтан Ууганцэцэг нарыг урьж багш сурагчидтай хамтран ажиллаж үр дүнтэй өнгөрүүлсэн нэг өдөр байлаа. Үйл ажиллагааны хүрээнд: 1. Багш М.Бадрахцэцэг Martha нар 8-р ангид "We save our world" сэдвээр үзүүлэх хичээл заалаа

Төв аймагт зохион байгуулагдсан самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 40 байгууллагын 1500 тамирчин оролцсоноос Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын баг тамирчдаас 51 кг жинд 86 ангийн сурагч А.Ганчимэг хүрэл медаль 55 кг жинд 66 ангийн сурагч Э.Болор-од хүрэл медаль хүртэж амжилттай оролцлоо.

U-15 насны "Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээн" 4 сарын 15,16-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнд: Охидын баг 3-р байр "ХҮРЭЛ_МЕДАЛЬ", Э.Мөнхжин "ШИЛДЭГ_ХАМГААЛАГЧ"-ААР ШАЛГАРЧ "АЛТАН МЕДАЛЬ" ЦОМЫН ЭЗЭН боллоо.

Сүхбаатар СУР" олон хотын нээлттэй олон улсын таеквондогийн тэмцээн 2023 оны 4-р сарын 22, 23 -нд Баруун-Урт суманд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Энэхүү тэмцээнд 9а ангийн сурагч Т.Мөнхзаяа тулааны төрөлд мөнгөн медаль, хосын туль буюу тулааны үзүүлбэрийн төрөлд хүрэл медаль хүртсэн. Анги удирдсан багш нарын зөвлөгөөнийг амжилттай зохион байгууллаа. Уг зөвлөгөөнөөр боловсролын салбар дах хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх арга зүй, эрсдэлт нөхцөлд буй хүүхдийг илрүүлэх, үйлчилгээ үзүүлэх зэрэг мэдээллийг танилцуулж, АУБ нар сайн туршлагаа түгээн дэлгэрүүлж, цаашид ажиллах зөвлөмж чиглэл солилцлоо.

5 Дугаар сарын 5,6-ны өдрүүдэд Жавхлант шарга-2023 арга хэмжээ тус суманд зохион байгуулахтай холбоотой Уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, хамгааллын талаар уяачидтай уулзалт зохион байгууллаа. Уг уулзалтаар уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, хамгаалал, эцэг эхтэй хийх гэрээ, зөвшөөрлийн хуудас, уралдаанч хүүхдийн даатгал, хичээлийг тасалдуулахгүй байх талаар мэдээлэл өгч ажиллалаа

2022-2023 оны хичээлийн жилд 1-р ангид 66 сурагч элсэн суралцаж, уншиж, бичиж, бодож сурснаа тайлагналаа

Сөб багш нар зориулсан “Хүүхдийн хөгжлийн үнэлгээний арга зүй” цахим сургалт 6-н бүлгийн багш Дуу хөгжмийн багш нар хамрагдаж батламжаа гардан авсан.

1. ХАЙРЦАГ ДҮҮРЭН ХАЙР ♥Сайн үйлсийн аянд байгалийн болон гэнэтийн давтагдашгүй хүчин зүйлд өртсөн 3-р багийн малчин А.Батболдын гэр бүлд сэтгэлийн дэмжлэг үзүүлээ. "Багачуудын Улаан Загалмайн "Тусч хүүхдүүд" клубээс санаачлан зохион явуулсан сайн үйлсийн аянд Хүүхдийн цэцэрлэгийн хамт олон анги бүлэг эцэг эхчүүдийн нийт 927,000 төгрөг
ЗДТГ - Соёлын төв - Хаан банк -Төрийн банк Аж ахуй нэгжийн 428,000 төгрөг
Нийт:1.355.000 - бэлэн мөнгө хандиваар цуглаж
Зах зээлийн үнээр 600.000-төгрөгийн Хүнс бараа, Хувцас, гэр ахуй хэрэгсэл хандиваар цугласныг хүлээлгэнэгч ажиллаа.
2. "Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдэд " зориулсан сургалтын ном , тоглоомын 25 багцыг шинэчлэлээ. Орчин үеийн шинэлэг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон чанарын шаардлага хангасан 73 төрлийн, 231 тоглоом ,үлгэр , дуу, шүлэг, түргэн хэллэг зэрэг 86-н төрлийн номын багц, нийт-197 номтой болж, хувилбарт сургалтын багцаа хөдөөгийн малчдын хүүхдэд хүргэн ажиллахад бэлэн болсон.
3. Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийн хурлаар хүүхэд хамгааллын нэг сарын турш аялан явах тугийг гарган авч төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.
4. Сургалтын байгууллага багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнийг үнэлэх үнэлгээний баг эрхлэгчийн тушаалаар 5 н хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Манай цэцэрлэг нь 6-н бүлэгтэй ердийн бүлэгтээ 242 хүүхдийг хамруулдаг. Үүнээс түүвэрийн аргаар 5-н бүлгийн багш, дуу хөгжмийн багш нийт-6 багш 100% хамрагдсан
5. " Сургууль цэцэрлэгийн залгамж холбоо бэхжүүлэх бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг " Сургуулийн орчинтой танилцуулах экскурс аяллыг зохион байгууллаа.Мөн бэлтгэл бүлгийн 78 хүүхдийг бэлтгэл хөтөлбөрт 14 хоног хамрагдсан.
6. Хос бичигтэн болохтой холбогдуулан төрийнх албан хаагчдад мэдээлэл хүргэх Судалгаа авах , Үндэсний бичгийн мэдлэг шалгах тест ажиллуулах

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын төв 4 дүгээр сард:

- Ирсэн бичиг – 6
- Явсан бичиг – 2
 - Хариутай бичиг – 0
 - Хугацаандаа явсан бичиг – 0
 - Хугацаа болоогүй бичиг – 0
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

1.1. Авъяаслаг Монголчууд шоуны шилдэг оролцогч, МУСТА, ая зохиогч, дуучин Даулетбекийн БЕРДИБЕК-ийн "ЧИН ЗҮРХ" анхны аялан тоглолт 2023.04.13-ны өдөр Сүхбаатар суманд тоглогдсон. Тоглолтын танхимаар 110 хүнд хүрсэн.

1.2. "ДАСГАЛЖУУЛАГЧ" Монголын уран сайхны кино өнөөдөр буюу 2023.4.18-ны өдөр Соёлын төвийн үзвэрийн танхимаар олон нийтэд сонирхуулсан. Кино үзвэрийг нийт 56 хүн үзэж сонирхсон болно.

1.3. "Бэлчээрийн талхагдлыг бууруулахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулах нь" зүүн бүсийн хэлэлцүүлэгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн Ц.Идэрбат, Аймгийн Засаг дарга М.Идэрбатаар ахлуулсан ажлын хэсэг болон 5 сумын малчдын төлөөлөл оролцсон. Нийтдээ танхимаар 102 хүнийг хамруулсан.

1.4. Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл залуучуудын хөгжлийн газраас "Хүүхдийн хөгжил хамгаалал"-ыг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад талуудын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан "Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийг чадавхжуулах, арга зүй олгох" сургалтанд Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болорцэцэг хамрагдсан. Үүнтэй холбогдуулан Хүүхэд хамгааллын жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Хамрагсад 1.

1.5. ХАБЭА болон галын аюулгүй байдлын талаар Аймгийн Соёл урлагийн газраас зохион байгуулсан цахим сургалтанд соёлын төвийн дарга, бүжгийн багш, техникч нар хамрагдсан. Мөн ЗДТГ-аас зохион байгуулсан ХАБЭА-н сургалтанд 3 албан хаагч хамрагдсан. 4-р сард "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сар" тохиож буйтай холбогдуулан сарын аяны төлөвлөгөөг боловсруулж баталсан, мөн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын журмыг боловсруулан албан хаагчдын дотоод хурлаар хэлэлцсэн. Хамрагсад 3.

1.6. Сүхбаатар сумын "Хэлний бодлогын зөвлөл"-өөс төрийн албан хаагчдын "Үндэсний бичиг"-ийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт зохион байгуулагдсан. Үүнд Соёлын төвийн 5 албан хаагч хамрагдсан.

1.7. Аймгийн аварга шалгаруулах Волейболын тэмцээн 4 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Сүхбаатар суманд зохион байгуулагдсан. Энэхүү тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд дугуйлангийн сурагчдын үкүлэлэ хөгжмийн үзүүлбэр, охидын хамтлаг дуу зэрэг урлагийн номер бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Хамрагсад 8. Нийт 336 хүнд хүрсэн.

1.8. Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийн ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэх хуралд Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болорцэцэг хамрагдсан. Үүнтэй холбогдуулан байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

ХОЁР: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2.1. “ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх аяны хүрээнд Х.К.Андерсений “Шүдэнз худалдагч охин”, Э.Эрдэнэбаярын “Бумбардай” зохиолоос сэдэвлэсэн “ Би зураг зурах дуртай” гар зургийн уралдааныг 14 хугацаатай зарлаж уралдааны шилдэгийг шалгаруулсан. Гар зургийн уралдаанд 1-р байранд 46 ангийн сурагч Г.Бямбарагчаа, 2-р байранд 56 ангийн сурагч Э.Мөнхжин, 3-р байранд 6а ангийн сурагч Э.Жижигшагай нар шалгарав. Тэмцээнийг 3-р багийн иргэн сумын сайн малчин Г.Лхамжав 100,000 төгрөгөөр ивээн тэтгэж дэмжин ажиллалаа. Хамрагсад 16.

2.2. Уншигчдын ном унших идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх, судар эгшиглэн уралдаанд оролцогчдыг сэдэлжүүлэх ном унших аргачлалыг зааж зөвлөгөө өгөх зорилгоор “СУДАР ЭГШИГЛЭН” төслийн нээлттэй хаалганы өдөрлөгийг танхимаар зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд төслийн санаачлагч, төслийн багийн гишүүд болох Сүхбаатар аймгийн номын санч В.Энхтуяа, ахмад багш МУГБ Д.Сэнгэдорж, ахмад багш Гандиймаа нар оролцлоо. Төслийн нээлтийн арга хэмжээгээр номын тэмдэглэлийн үзэсгэлэн гаргаж сонирхуулав. Энэхүү үйл ажиллагаанд нийт 68 хүн хамрагдсан. Судар эгшиглэн 2023 төсөлд Сүхбаатар сумаас насанд хүрэгсэд-15, 1-5 ангийн сурагчид 16, 6-9 ангийн сурагчид-14 нийт 55 хүн оролцож байна.

2.3. “Дэлхийн номын өдөр” хүүхдийн номоор төрөлжсөн номын үзэсгэлэн, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион явуулсан. Энэхүү арга хэмжээнд 58 хүүхэд хамрагдсан. АХА тэмцээнд 7а ангийн сурагч Н.Нардүүрэн, 8а ангийн сурагч Г.Ганпүрэв нар шалгарав.

2.4. Төрийн тахилгат Алтан Дарь овоог тахьж эхэлсний 130 жилийн ой, Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жилийг тохиолдуулан Дарьгангын аман билгийн сурталчлах, хүүхэд залууст өвлүүлэх, танин мэдэхүй, ёс зүй, хүмүүжил, соёлын боловсрол олгох үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулах зорилгоор хэрэгжиж байгаа “Үлгэрч Сүхбаатарчууд” соёлын боловсролын хөтөлбөрийн хүрээнд номын сангийн уншигчдын дунд “Дарьганга үлгэрүүд” чанга уншлагыг 32 хүүхэд зохион явуулсан.

2.5. Сүхбаатар аймгийн номын санч М.Нарангэрэлээс цахим праграммын сургалт авсан.Номын сангийн праграммд алдаатай орсон номуудыг засварлах, дахин оруулах ажлыг хийж эхлэж байна. Хамрагсад 1.

4-р сард шинэ уншигч-10 ирэгсэд 209 гэрээр олгосон ном 18 танхимаар олгосон ном 205 нийт 223 ном олгосон. Шинэ номын үзэсгэлэн-1 удаа 75 ширхэг номоор 58

хүүхдэд үйлчлэв.

ГУРАВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

3.1. Шинжлэх Ухааны Академийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгээс зохион байгуулж байгаа, “Талын эзэнт гүрэн” төслийн багтай хамтран Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт орших Дарханхаан уул, Баянхундар уул, Цагаан дэрсний булш хиргисүүрүүдийг судалгаанд хамруулах тал дээр хамтран ажилласан. Мөн энэ үеэр Сүхбаатар сумаас зүүн хойд зүгт орших Цагаан дэрсний орчимд Хүрлийн үеийн Улаан зуух хэлбэрийн 52 ширхэг дөрвөлжин булшийг шинээр илрүүлсэн. Хамрагсад 5

3.2. Сүхбаатар сумын Орон нутаг судлах музейд хадгалагдаж байгаа 39 ширхэг Соёлын баримтат өвийг Баримтат өв бүртгэх шинэчилсэн маягтыг дагуу бүртгэж авсан. Үүнд Гар бичмэл – 1, Даавуу зөөлөн эдлэлийн төрлийн баримтат өв – 4, Тамга тэмдэг – 3, Баримт бичиг – 14, Гэрэл зураг – 1, Ил захидал – 2, Дуу бичлэг – 7, Зоос мөнгөн тэмдэг – 6 бүртгэсэн болсон.

3.3. “Баянцагааны тал” байгалийн нөөц газарт мөрдөх хамгаалалтын горимыг танилцуулах уулзалтыг сумын байгаль орчны байцаагчтай хамтран зохион байгуулсан. Тус уулзалтанд 23 хүн хамрагдаж, санал бодлоо солилцсон.

3.4. “Орон нутаг судлах музей”-г олон нийтэд 3 удаа нээлттэй, үнэ төлбөргүй үзүүллээ. Үүнд Улаанбаатар хотын Цэргийн госпиталийн албаныхан, сумын ЕБС-ийн төгсөгчдийн төлөөлөл, ЕБС-ийн Цэндмаа багштай 7а ангийн хамт олон гэх мэтээр 4-р сард нийт 57 хүн ОНСМ-г үзэж сонирхсон.

ДӨРӨВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

4.1. Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх дасгал хөдөлгөөнөөр эрүүлжих, хөдөлгөөний дутагдлаас ангижрах, хөдөлгөөний эвсэлтэй болгох зорилгоор “ЭМГҮЙГЭЭР ЭРҮҮЛЖЬЕ” нийтийн цэнгээнт бүжгийн анхан шатны сургалтыг 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн Монголын бүжгийн спортын холбооны гишүүн Нийтийн цэнгээнт бүжгийн II зэрэгтэй багш Ж.Энхбаатар, Монголын шугаман бүжгийн холбооны багш Д.Болортуяа нартай хамтран зохион байгуулж байна. Тус сургалт нь 10 хоног үргэлжлэх бөгөөд Хүмүүн төрөлхтөн, Задгай цагаан, Ёохор, Румба, Өндөр дэлгүүр, Вальс Бостон, Краковъяк, Венгерка, Падеспани, Түстеп, Фокстрот зэрэг бүжгийг зааж сургаж байна. Нийтийн цэнгээнт бүжгийн сургалт нь өдөрт 2 удаа хичээллэж байгаа бөгөөд нийтдээ 50 хүн хамрагдаж байна.

5.1. Дуу хөгжмийн багш Л.Батжаргал ЕБС-ийн сурагчдад үкүлэлэ, цахилгаан хөгжмийн дугуйлан хичээллэсэн. Хамрагсад 21.

5.2. Ахмадын дунд нийтийн цэнгээнт бүжгийг 2 удаа зохион байгуулсан. Нийт 44 хүн хамрагдсан.

4.2.

ТАВ: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1. Бүжгийн багшийн орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, Нийгмийн ухааны дээд сургуулийг нийгмийн ажилтан мэргэжлээр төгссөн Дашийн Дэлгэртуяаг бүжгийн багшаар 4 сарын 3-ны өдрөөс эхлэн авч ажиллуулж байна.

5.2. Гэнэтийн аюулаас болж ихээхэн хохирол амссан зорилтот өрхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор Улсын тэргүүний цэцэрлэгээс зохион байгуулсан ХАЙРЦАГ-ДҮҮРЭН-ХАЙР хандивын аянд Соёлын төвийн албан хаагчид нэгдэж, мөнгөн дэмжлэг үзүүлсэн.

5.3. Техникч Б.Батболд цэвэр усны шугам сүлжээний доголдолыг засч янзалсан, хагарсан цонхыг шиллэж, өрөө тасалгааны урагдаж, салсан хуулгыг нааж сэлбэсэн.

5.4. Албан хаагчид бүх нийтийн цэвэрлэгээнд гарч, хариуцсан нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэсэн.

5.5. Байгууллагын дотоод хурлыг 2 удаа зохион байгуулж, цагийн үеийн асуудал болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцсэн.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Зүүн бүсийн жишиг соёлын төв нь 2023 оны хоёрдугаар сарын байдлаар **22** үйл ажиллагаа зохион байгуулж, танхимын болон явуулын үйлчилгээгээр танхимаар **810** үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээ, арга хэмжээг хүргэн ажилласан. Хамрагсадын тоо **187**

МЭДЭЭ ГАРГАСАН :

Дотоод ажилтан, Хууль, эрх зүйн мэргэжилтэн

/С.Ариунзаяа/

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/